

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс
Судалгаа, мэдээлэл лавлагааны алба

**ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙГ ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНД БИЕЧЛЭН ОРОЛЦУУЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)
СТ-17/207

ЗАХИАЛАГЧ: Ц.Цолмон
Б.Эрдэнэбилэгт (Ph.D)

ХЯНАСАН:

СУДЛААЧИД: Г.Билгээ
Ц.Болормаа
Д.Жигваагүнсэл
Т.Саулегүл
Д.Халиун

Улаанбаатар
2017 он

АГУУЛГА

НЭГ. Парламентын гишүүдийг чуулган болон байнгын хорооны хуралдаанд биечлэн оролцуулах хууль зүйн зохицуулалт.

а) Парламентын тухай хууль болон Парламентын Дэгийн тухай хуулийн хүрээнд:

- Канад
- Казахстан
- Турк

б) Үндсэн хуулийн хүрээнд:

- Гишүүний бүрэн эрхэд хариуцлага тооцох
- Бусад

ХОЁР. Парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгөх талаарх бусад орнуудын хуулийн зохицуулалт, техник, зохион байгуулалт.

- Албани
- Болгар
- Итали
- Шри-Ланк
- Уганда

НЭГ. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙГ ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД БИЕЧЛЭН ОРОЛЦУУЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

а) Парламентын тухай хууль болон Парламентын Дэгийн тухай хуулийн хүрээнд:

Мөн судалгаанд Канад, Турк, Казахстан улсын Парламентын тухай хууль болон парламентын Дэгийн холбогдох зохицуулалтыг оруулав.

Канад: Канадын Парламентын тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар “Парламентын аль нэг танхимын гишүүн нэг сарын дотор эсхүл нэг чуулганы хуралдааныг 21-ээс дээш хоног тасалсан тохиолдолд хоног тус бүрт 120 ам.долларыг гишүүний цалин хөлснөөс хасч тооцно”¹ гэж зохицуулсан байна.

Казахстан: Парламентын дэгийн тухай хууль

110.Гишүүн нэг Чуулганы хугацаанд Парламентын Танхимуудын хамтарсан хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй тохиолдолд түүний хуралдаанд оролцоогүй өдрийн хөдөлмөрийн хөлсийг олгохгүй.

Гишүүн Парламентын Танхимуудын хамтарсан болон түүний байгууллагуудын хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр 1 сараас дээш хугацаанд оролцоогүй бол хуралдаанд оролцоогүй хугацааны үеийн дараахь эрхийг олгодоггүй байна. Үүнд:

- хөдөлмөрийн хөлс;
- авто-тээврийн хэрэгслийн үйлчилгээ;
- тээврээр зорчих эрхийн бичиг;
- томилолт;
- томилолтын зардал;
- эмчилгээ, чийрэгжүүлэх болон рашаан сувиллын үйлчилгээ.

Гишүүн Танхимын, эсхүл Танхимуудын хамтарсан хуралдаанд оролцоогүй нөхцөлд дээрх шийдвэрийг холбогдох Танхимын дарга, Танхимын байгууллагуудын хуралдаанд оролцоогүй нөхцөлд холбогдох Танхимын Хороо /Танхимын даргын дэргэдэх зөвлөл/ гаргана.

111.Гишүүн саналын эрхээ биечлэн хэрэгжүүлнэ. Хуралдаанд оролцоогүй гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.

114.Гишүүн нь зөвхөн Танхимын, эсхүл Парламентын холбогдох байгууллагын дарга нарын зөвшөөрсний дагуу Парламент болон түүний байгууллагуудын хуралдаанд оролцохгүй байж болно.

Турк: Үндэсний Их Хурлын дэг

138-р зүйл: Гишүүний хуралдаан завсарлалт

Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, эсхүл чөлөө авалгүйгээр нэг сарын дотор нийт таван удаагийн нэгдсэн хуралдааны үйл ажиллагаанд оролцоогүй бол Их Хурлын Удирдах Хорооны тухайн гишүүнийг эгүүлэн татах тухай саналыг Үндсэн хуулийн болон Хууль зүйн хорооны гишүүдээс бүрдсэн хамтарсан хороонд шилжүүлэх ба хамтарсан хороо нь гишүүнийг эгүүлэн татах тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэж шийдвэрийн төслийг бэлтгэнэ.

¹ <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/p-1/page-10.html#h-37>

Энэхүү шийдвэрийн төслийг их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гишүүнийг эгүүлэн татахыг нийт гишүүдийн олонхийн саналаар дэмжвэл гишүүний бүрэн эрх дуусгавар болно. Тухайн гишүүн хүсвэл хамтарсан хороонд эсхүл Их Хурлын нэгдсэн хуралдаанд өөрийгөө өмгөөлөх, эсхүл аль нэгэн гишүүнээр өмгөөлүүлэх эрхтэй.

Мөн түүнчлэн нэг жилийн дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, эсхүл чөлөө авалгүйгээр нийт 45 хуралдааны үйл ажиллагаанд оролцоогүй гишүүний нэмэлт хангамжийг 3 сар тасална.

б) Үндсэн хуулийн хүрээнд:

Судалгаанд www.constituteproject.org цахим мэдээллийн хуудас дахь 192 орны Үндсэн хуулиас үсгийн дарааллаар, санамсаргүй түүврээр 80 улсыг сонгов.

Ийнхүү үзэхэд сонгон авсан **80** улсын **44**-аас парламентын гишүүнийг Чуулган болон Байнгын хорооны хуралдаанд оролцуулах хууль зүйн зохицуулалтыг харьцуулсан хүснэгт 1-ээр үзүүлэв. Тус мэдээллийг нэгтгэн үзвэл:

Гишүүний бүрэн эрхэд хариуцлага тооцох	Бусад
<ul style="list-style-type: none"> • Зөвшөөрөлгүйгээр эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Чуулганы болон Байнгын хорооны <u>хуралдаанд оролцоогүй гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс – 35 /Хүснэгтээс үзнэ үү/ • Гишүүдийг Чуулган болон Байнгын хорооны <u>хуралдаанд оролцоогүй бол бүрэн эрхийг түдгэлзүүлэх</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс -3 /Мексик, Филиппин, Финланд/ • Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр <u>хуралдаанд оролцоогүй бол гишүүнийг эгүүлэн татах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс -1 /Турк/ байна. 	<ul style="list-style-type: none"> • Чуулганы болон Байнгын хорооны <u>хуралдаанд оролцоогүй гишүүний цалингаас суутгах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс – 1 /Грек/ • Гишүүн <u>бүрэн эрхээ биечлэн хэрэгжүүлэх</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс – 2 /Иран, АНУ/ • Гишүүн бүрэн эрхээ биечлэн хэрэгжүүлээгүй, <u>хуралдааны санал хураалтад биечлэн оролцоогүй бол торгох шийтгэл оногдуулах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс -3 /Ирланд, Казахстан, Кувейт/

Гишүүний суугаагүй хуралдааны тоо, парламентын үйл ажиллагаанд оролцоогүй хугацааг улс орон бүр харилцан адилгүй тогтоосон бөгөөд **хамгийн багадаа нэг сард 5 удаагийн хуралдаан тасалсан, хамгийн ихдээ нэг жил парламентын үйл ажиллагаанд оролцоогүй бол** парламентын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай заасан байна.

Нөгөө талаас хуралдаанд суугаагүй болон парламентын үйл ажиллагаа (*parliament work* гэж нэрлэсэн байх ба үүнд Чуулган, Байнгын хороо, Бүлгийн хуралдаан болон гишүүний бүрэн эрхэд хамаарах бусад ажил үүрэг)-д оролцоогүй үндэслэлээр парламентын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохдоо:

- Эрх бүхий албан тушаалтан болон Спикерээс бичгээр авсан зөвшөөрөл
- Хүндэтгэн үзэх шалтгаан гэсэн үндсэн хоёр нөхцөлийг харгалзан үзнэ.

Иймд “хүндэтгэн үзэх шалтгаан” гэх нэр томъёоны хууль зүйн тайлбарыг оруулав. **Хүндэтгэн үзэх шалтгаан (reasonable excuse, justifiable, important reason)** – Монгол Улсын хууль тогтоомжид заасан олонтаа хэрэглэгддэг хууль зүйн

хэвшмэл хэллэг. Хуулийн эх бичвэрийн холбогдох заалтын утга санаанд анхаарал хандуулах боловч хүндээр өвчилсөн, өвчтэй хүн асарсан, томилолтоор гадаад ба дотоодод ажилласан, сургалтад хамрагдсан, хорио цээр тогтоогдсон, байгалийн гамшиг тохиолдсон, гэнэтийн осолд орсон болон эдгээртэй адилтган үзэх бусад нөхцөл байдлыг хамааруулан үзнэ².

АНУ-ын Үндсэн хуулийн 1-р хэсгийн 5-р зүйлээр Гишүүний ирцтэй холбоотой асуудлыг зохицуулсан байна. Үүнд:

“Танхим бүр сонгууль, түүний үр дүн болон өөрийнх нь гишүүд шаардлагад нийцсэн эсэхийг өөрөө хянана. Танхим бүрийн гишүүдийн ердийн олонхи нь ажлаа явуулах ирцийн бүрдэлтийг хангана. Гэхдээ түүнээс цөөн тооны гишүүдийн ирцтэй байвал хуралдааныг өдөр өдрөөр хойшлуулж болох бөгөөд тэдэнд тухайн Танхимын тогтоосон журам болон шийтгэлийн арга хэмжээг хэрэглэн эзгүй байгаа гишүүдийг албадан авчирч хурлын ирцийг бүрдүүлэх эрх олгож болно.

Танхим бүр хуралдааныхаа дэгийг тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь төлөө гишүүнээ шийтгэж, мөн гуравны хоёрын саналаар гишүүнийг бүрэлдэхүүнээсээ хасаж болно.

Танхим бүр хуралдааныхаа явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, түүнийгээ тогтмол нийтлэх ёстой бөгөөд түүндээ нууцын шаардлагад хамаарна гэж өөрсдийн үзсэнээс бусад зүйлийг оруулна; Аливаа асуудлаар аль ч Танхимын гишүүдийн “төлөө” болон “эсрэг” өгсөн саналыг хуралдаанд оролцогчдын тавны нэгийн хүсэлтээр сэтгүүлд нийтэлнэ.” гэж заажээ.

Парламентын гишүүдийг Чуулган болон Байнгын хорооны хуралдаанд биечлэн оролцуулах Үндсэн хуулийн зохицуулалт

Хүснэгт 1

№	УЛСЫН НЭР	ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ
Нэг: Зөвшөөрөлгүйгээр эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Чуулганы болон Байнгын хорооны хуралдаанд оролцоогүй гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Австрали 1901 (rev. 1985)	38.Гишүүн нь парламентын хуралдаанд зөвшөөрөлгүй болон шалтгаангүйгээр 2 сарын турш ирээгүй тохиолдолд түүний орон тоог сул болсонд тооцно.
2.	Бразил 1988 (rev. 2015)	55. Депутатууд болон Сенаторуудын мандатын эрх дараах тохиолдолд хүчингүй болно: III.Ээлжит чуулганы хуралдааны 1/3-д эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд оролцоогүй бол;
3.	Гамби 1996 (rev. 2004)	90. Дараах тохиолдолд Үндэсний Ассамблейн гишүүн байх эрхийг хасна (албан үүргээс нь чөлөөлнө): 90.7. Үндсэн хуулийн 170 дугаар зүйлд заасны дагуу төрийн улс төрийн албанаас чөлөө авснаас бусад тохиолдолд шалтгаангүйгээр ажил тасалсан бол;
4.	Гана 1992 (rev. 1996)	97.1.Дараах тохиолдолд Парламентын гишүүний суудал суларсанд /ор гарсан/ тооцно: с.Спикерээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр нэг Чуулганы хугацаанд 15 удаа хуралд суугаагүй, эсхүл Парламентын чуулганыг зарлан хуралдуулахад ирээгүй бөгөөд ийнхүү ирээгүй шалтгаанаа Парламентын гишүүний Дархан эрхийн Хороонд зөвтгөх тайлбар хийж чадаагүй бол гишүүний суудал суларсанд тооцно.
5.	Гренада 1973	27.2.гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө

² С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг.,2015. 575 дахь тал.

	(reinst. 1991, rev. 1992)	дуусгавар болгоно: А. Сенатын танхимын хуралдаанд Сенатын танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол. 33.2.Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: А. Төлөөлөгчдийн танхимын хуралдаанд Төлөөлөгчдийн танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
6.	Гүрж 1995 (rev. 2013)	54.2.Дараах тохиолдолд парламентын гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно: f.парламентын гишүүн 4 сарын хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Парламентын ажилд оролцоогүй бол түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.
7.	Зимбабве 2013	129.1.Парламентын гишүүний суудлыг дараах тохиолдолд суларсанд тооцно: f/ гишүүн нь Спикер, эсхүл Сенатын даргаас зөвшөөрөл авалгүй парламентын чуулганы хуралдааныг дараалсан 21 өдрөөс дээш хоногоор тасалсан бол парламентын нийт гишүүдийн талаас дээш хувийн саналаар тухайн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болсонд тооцно.
8.	Канад 1867 (rev. 2011)	31. Дараах тохиолдолд Сенаторын суудал суларсанд тооцно: 1.Хэрэв дараалсан хоёр парламентын хуралдааны турш өөрийн ирцээ Сенатад ирүүлээгүй бол;
9.	Кени 2010	103.Дор дурьдсан тохиолдолд парламентын гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно: б/ хэрэв парламентын чуулганы хугацаанд Спикерээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээр холбогдох Танхимын Үндэсний Ассамблей, Сенат/ хуралдаанд 8 удаа оролцоогүй, эсхүл холбогдох Хорооны хуралдаанд оролцоогүй бөгөөд ийнхүү хуралдаан оролцоогүй шалтгаанаа зөвтгөн тайлбарлаж чадахгүй бол;
10.	Кирибати 1979 (rev. 1995)	57.Дор дурьдсан тохиолдолд парламентад сонгогдсон гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно: в/хэрэв Парламентын дэгийн тухай хуульд тусгайлан заасан хугацаа болон нөхцөлд парламентын хуралдаанд оролцоогүй бол;
11.	Косово 2008	70.3.Дор дурьдсан тохиолдолд Ассамблейн төлөөлөгчийн бүрэн эрх дуусах, эсхүл хүчингүй болно: 5/гишүүн дараалан 6 сар Ассамблейн үйл ажиллагаанд оролцоогүй бол түүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно. Онцгой тохиолдолд Ассамблей өөрөөр шийдвэрлэж болно.
12.	Кыргыз 2010	73.3.Энэ зүйлийн 2-т зааснаас гадна дараах тохиолдолд Жогорку Кенешийн гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно: g.гишүүн нэг чуулганы хугацаанд шалтгаангүйгээр 30 ба түүнээс дээш ажлын өдөр Жогорку Кенешийн хуралдаанд суугаагүй бол;
13.	Либерти 1986	38.Танхим бүр өөрийн дэгийг баталж, дэгээр тогтоосон журмыг сахин биелүүлэх үүрэгтэй ба Дэгт заасан журмын дагуу нийт гишүүдийн 2/3-ийн дэмжлэгээр гишүүнийг хөөж болно.
14.	Ливи 2011 (rev. 2012)	22.Хэрэв Үндэсний шилжилтийн зөвлөлийн гишүүн нь гишүүнийхээ үүргийг зөрчсөн бол өөрийн гишүүний эрхээ хасуулна. Гишүүний эрхийг хасах асуудлыг Үндэсний шилжилтийн зөвлөлийн нийт гишүүдийн 2/3-ийн саналаар шийдвэрлэнэ.
15.	Лихтенштейн 1921 (rev. 2003)	53.Төлөөлөгчид парламентаас товлон зарласны дагуу Төрийн ордонд өөрийн биеэр хүрэлцэн ирэх ёстой. Хэрэв гишүүн парламентын эхний товын дагуу хүрэлцэн ирэх боломжгүй болсон бол нэн даруй энэ тухайгаа шалтгааны хамт Төрийн ордонд, харин дараа дараагийн тохиолдолд Парламентын даргад тус тус мэдэгдэнэ. Хүрэлцэн ирэхгүй байх шалтгаан нь тогтмол шинжтэй болж, хэрэв гишүүнийг орлох боломжгүй бол нөхөн сонгууль явуулна.
16.	Малайз 1957 (rev. 2007)	52. Гишүүний хуралдаанд оролцоогүй байдал Парламентын аль нэг танхимын гишүүн нь чөлөө авалгүйгээр Чуулганы хуралдаанд 6 сарын турш оролцоогүй бол түүний суудлыг суларсанд тооцно.
17.	Сейшелийн	81.1.Дараах тохиолдолд Үндэсний Ассамблейн гишүүний бүрэн эрх

	Арлууд 1993 (rev. 2011)	дуусч, гишүүний суудал суларсанд тооцно /ор гарсан/ d/ Спикерээс бичгээр зөвшөөрөлгүй авалгүй ii/ нэг чуулганы хугацаанд шалтгаангүйгээр 90 ба түүнээс дээш ажлын өдөр чуулганы хуралдаанд суугаагүй бол.
18.	Сент-Венсент ба Гренадин 1979	29.3.Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гишүүний суудлыг дараах тохиолдолд суларсанд тооцно: a/ Парламентын чуулганы хуралдаанд Парламентын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
19.	Сент-Китс ба Невис 1983	31.3. Парламентын томилогдсон, эсхүл сонгогдсон гишүүний суудлыг дараах тохиолдолд суларсанд тооцно: a/ Парламентын чуулганы хуралдаанд Парламентын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
20.	Сент Люсиа 1978	27.2.Сенатын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: a/ Сенатын танхимын хуралдаанд Сенатын танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол. 34.2.Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: Төлөөлөгчдийн танхимын хуралдаанд Төлөөлөгчдийн танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
21.	Сан-Томе Принсипи 1975 (rev. 1990)	85.2. Өөрийн албан үүргээ /ноцтой/ биелүүлдэггүй гишүүнийг Үндэсний Ассамблейн нууц санал хураалтаар, гишүүдийн 2/3-ны саналаар гишүүний бүрэлдэхүүнээс хасаж болно.
22.	Сингапур 1963 (rev. 2010)	46.2.4.Дараах тохиолдолд Парламентын гишүүний суудлыг суларсанд тооцно: d/ Парламентын чуулганы /эсхүл өөрийн томилогдсон Байнгын Хорооны/ хуралдааны Спикерээс зөвшөөрөл авах эрх цуцлагдахаас өмнө авалгүй 2 сар дараалж хуралдаанд суугаагүй бол.
23.	Судан 2005	87.1.Дараах тохиолдолд Парламентын гишүүний суудлыг суларсанд тооцно: c/ Тухайн танхимынхаа нэг бүтэн чуулганд зөвшөөрөлгүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй.
24.	Суринам 1987 (rev. 1992)	68.1.Гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: f) хэрэв гишүүн Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд 5 сар оролцоогүй.
25.	Сьерра Леон 1991 (reinst. 1996, rev. 2008)	77.1.Парламентын гишүүн нь дараах тохиолдолд ажлаа хүлээлгэж өгнө: e/ Парламентын чуулганы хуралдаанд Чуулганы хуралдааны дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
26.	Тайланд 2014	9.5.Дараах тохиолдолд Парламентын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: Парламентын чуулганы хуралдааны дэгт заасан чуулганы хуралдааны санал хураалтад өгөх саналын тоо нь тогтоосон тооноос дутсан бол.
27.	Танзани 1977 (rev. 1995)	71.Парламентын гишүүний бүрэн эрх дуусч, гишүүний суудал суларсанд тооцно /ор гарсан/ c/Парламентын гишүүн Спикерээс зөвшөөрөл авалгүй чуулганы хуралдаанд дараалж 3-с дээш удаа оролцоогүй бол.
28.	Унгар 2011 (rev. 2013)	4.3.Дараах тохиолдолд Үндэсний Ассамблейн гишүүний бүрэн эрх дуусгавар болно: f) хэрэв гишүүн Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд 1 жил оролцож чадаагүй бол түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.
29.	Шри-Ланк 1978 (rev. 2015)	66. Дараах тохиолдолд Парламентын гишүүний суудлыг суларсанд тооцно: f/ Парламентаас урьдчилан зөвшөөрөл авалгүй чуулганы хуралдаанд дараалсан 3 сарын хугацаагаар оролцоогүй бол.
30.	Ямайка 1962 (rev. 2011)	41.1.Дор дурьдсан тохиолдолд Сенатор болон Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно: в/хэрэв Парламентын дэгийн тухай хуульд тусгайлан заасан хугацаа болон нөхцөлд Танхимын хуралдаанд оролцоогүй бол;
31.	Тринидад Тобаго	43.2.Сенатын танхимын гишүүний суудлыг дараах тохиолдолд

	1976 (rev. 2007)	суларсанд тооцно: a/ Сенатын танхимын хуралдаанд Сенатын танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол. 49.2.Төлөөлөгчдийн танхимын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно: b/Төлөөлөгчдийн танхимын хуралдаанд Төлөөлөгчдийн танхимын дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
32.	Тувалу 1986	99.1.Парламентын гишүүний суудлыг дараах тохиолдолд суларсанд тооцно. c/ Парламентын чуулганы хуралдааныг Чуулганы хуралдааны Дэгт заасан хугацаа болон нөхцөлийн дагуу оролцоогүй бол.
33.	Өмнөд Африк 1996 (rev. 2012)	47.3.Парламентын гишүүнийг дараах тохиолдолд парламентын гишүүнээс нь хасна : 3/ Парламентын хуралдааныг зөвшөөрөлгүй тасалж, журамд холбогдох нөхцөлийг Парламентын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхээр тусгасан бол.
34.	Өмнөд Судан 2011 (rev. 2013)	63.1.Парламентын гишүүний дараах тохиолдолд парламентын гишүүнчлэлээ алдана: d/Парламентын хуралдааныг зөвшөөрөл, эсхүл шалтгаангүйгээр хэд хэдэн удаа тасалж, бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг танхим тус бүрийн дэгээр тогтоосон бол.
35.	Уганда 1995 (rev. 2005)	83.1.Парламентын гишүүний суудлыг дараах тохиолдолд суларсанд тооцно: d/Парламентын чуулган тасралтгүй хуралдаж байгаа тохиолдолд гишүүн Спикерээс бичгээр зөвшөөрөл авалгүй 15-с дээш хуралдаан тасалж, мөн хуралдаанд оролцоогүй шалтгааныг холбогдох Хороо нь хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзээгүй тохиолдолд.
Хоёр: Чуулганы болон Байнгын хорооны хуралдаанд оролцоогүй <u>гишүүний цалингаас суутгах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Грек 1975 (rev. 2008)	63.3.Сар бүр 5-аас дээш удаа хуралдаанд суугаагүй тохиолдолд түүнд сар бүр олгодог 31 өдрийн цалингаас эзгүй байсан хуралдаан бүрээр тооцон суутгана.
Гурав: Гишүүн <u>бүрэн эрхээ биечлэн хэрэгжүүлэх</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Иран 1979 (rev.1989)	85.Гишүүн бүрэн эрхээ биечлэн хэрэгжүүлэх ба бусад этгээдэд шилжүүлэхгүй.
Дөрөв: Гишүүн бүрэн эрхээ биечлэн хэрэгжүүлээгүй, хуралдааны санал хураалтад биечлэн оролцоогүй бол <u>торгох шийтгэл оногдуулах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Ирланд 1937 (rev. 2015)	15.10.Танхим бүр /Төлөөлөгчдийн танхим, Сенат/ өөрийн дүрэм, дэгийг батлах ёстой ба түүнийг зөрчсөн тохиолдолд торгуулийн шийтгэлтэй байна.
2.	Казахстан 1995 (rev. 2011)	52.1.Парламентын гишүүд нь Парламентын үйл ажиллагаанд биечлэн оролцох ёстой. Гишүүн Парламент дахь санал хураалтыг гагцхүү биечлэн хэрэгжүүлнэ. Гишүүн нь хүндэтгэх шалтгаангүйгээр Танхимууд /Сенат, Мажилис/, түүний хороодын хуралдаанд 3-аас олон удаа оролцоогүй болон саналын эрхээ шилжүүлсэн тохиолдолд түүнд хуульд заасны дагуу торгуулийн шийтгэл оногдуулна.
3.	Кувейт 1962 (reinst. 1992)	117.Үндэсний Ассамблей өөрийн дотоод дүрэмтэй байх ёстой... Гишүүн дотоод дүрэм зөрчсөн, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр Ассамблей болон хорооны хуралдаанд оролцоогүйн төлөө торгох шийтгэлийн хэмжээг Дотоод дүрэмд тодорхойлно.
4.	АНУ 1789 (rev. 1992)	Art 1.Сec 5. Танхим бүр сонгууль, түүний үр дүн болон өөрийнх нь гишүүд шаардлагад нийцсэн эсэхийг өөрөө хянана. Танхим бүрийн гишүүдийн ердийн олонхи нь ажлаа явуулах ирцийн бүрдэлтийг хангана. Гэхдээ түүнээс цөөн тооны гишүүдийн ирцтэй байвал хуралдааныг өдөр өдрөөр хойшлуулж болох бөгөөд тэдэнд тухайн Танхимын тогтоосон журам болон шийтгэлийн арга хэмжээг хэрэглэн эзгүй байгаа гишүүдийг албадан авчирч хурлын ирцийг бүрдүүлэх эрх олгож болно. Танхим бүр хуралдааныхаа дэгийг тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь

		төлөө гишүүнээ шийтгэж, мөн гуравны хоёрын саналаар гишүүнийг бүрэлдэхүүнээсээ хасаж болно.
Тав: Гишүүдийг Чуулган болон Байнгын хорооны <u>хуралдаанд оролцоогүй бол бүрэн эрхийг түдгэлзүүлэх</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Мексик 1917 (rev. 2015)	63. Төлөөлөгчдийн болон Сенатын танхим нь нийт төлөөлөгчдийн 50%-ийн ирц бүрдсэн тохиолдолд үйл ажиллагаагаа явуулна. Төлөөлөгч болон сенат нь танхимын аливаа үйл ажиллагаанд оролцож чадахгүй тухайгаа Спикерт урьдчилан мэдэгдэх ёстой. Аль нэг Төлөөлөгч, эсхүл Сенат нь Спикерийн зөвшөөрөлгүйгээр, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 10 өдөр чуулганы үйл ажиллагааг тасалдуулсан бол дараагийн ээлжит чуулганы үйл ажиллагаа эхлэх хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болно.
2.	Филиппин 1987	16. Парламентын танхим тус бүр өөрийн үйл ажиллагааны дүрмийг боловсруулах ба гишүүдийг ёс суртахуунгүй үйлдэл хийснийх нь төлөө шийтгэх, мөн түүнчлэн нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, огцруулах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр зохицуулж болно. Бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх хугацааг 60 хоногоос хэтрүүлж болохгүй.
3.	Финланд 1999 (rev. 2011)	28. Төлөөлөгч хүндэтгэх шалтгааны улмаас парламентын гишүүнээс чөлөөлөгдөх өргөдөл гаргавал парламент түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно. Төлөөлөгч нь өөрийн албан үүргээ нэг бус удаа бодитойгоор хэрэгжүүлээгүй бол Үндсэн хуулийн хорооны саналыг сонссоны дараа нийт Төлөөлөгчдийн 2/3-ын саналаар түүний бүрэн эрхийг дуусгавар болгох, эсхүл түр хугацаагаар түдгэлзүүлнэ.
Зургаа: Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр <u>хуралдаанд оролцоогүй бол гишүүнийг эгүүлэн татах</u> Үндсэн хуулийн зохицуулалттай улс		
1.	Турк 1982 (rev. 2011)	84. Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, эсхүл чөлөө авалгүйгээр нэг сарын дотор нийт таван удаагийн нэгдсэн хуралдааны үйл ажиллагаанд оролцоогүй бол Их хурлын удирдах хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар гишүүнийг эгүүлэн татах эсэхийг хэлэлцэж, нийт гишүүдийн олонхийн саналаар гишүүнээс нь эгүүлэн татна.

ХОЁР. ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ САНАЛ ХУРААЛТАД ХУРУУНЫ ХЭЭГЭЭР САНАЛ ӨГӨХ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТЕХНИК, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Олон улсын парламентын холбоо /IPU/-ноос зохион байгуулдаг “World e-Parliament Conference 2016” тайланд 88 улсын 114 парламентын танхимын ICT буюу мэдээлэл, холбооны технологитой холбоотой бүхий л мэдээллийг анкетын санал асуулгаар төвлөрүүлсэн байна. Судалгаанд хамрагдсан 112 танхимын 67% нь парламентын хуралдааны санал хураалтад ямарваа нэгэн төрлийн мэдээллийн технологи /IT/-ийн системийг ашигладаг байна. Үлдсэн танхимууд нь санал хураалтыг гар өргөх байдлаар явуулдаг ба тэдгээрийн 72% нь ирээдүйд цахим тоолуур нэвтрүүлнэ гэж хариулжээ. Санал хураалтад мэдээллийн технологийн систем ашигладаг танхимууд нь санал хураалтын төрөл бүрийн хэлбэрийг ашиглаж байгаа ба хамгийн их хэрэглэгдэж буй /35%/ систем нь гишүүний карт, эсхүл жетон, мөн гишүүн бүрийн суудалд суурилуулсан товчлуур /34%/ байна.


Дээрхээс гадна хоёр дахь шатны баталгаажуулалтыг ашиглаж болох ба хамрагдсан танхимуудын 8% нь биометрик үзүүлэлт /хурууны хээ/-ийг санал хураалтад ашиглаж байна. Мөн 8% нь санал хураалтаа гараар явуулж, тооцоолол буюу саналын хувийг тооцоолж гаргахдаа цахим тоолуур ашиглаж байна. Тухайлбал,

ИБУИНВУ-ын Лордуудын танхимд гишүүд нь “тийм”, “үгүй” гэгдэх лобби коридороор алхаж, нэрээ бүртгүүлж саналаа өгдөг бол клеркүүд нь таблетын аппликейшн ашиглан саналыг тоолдог байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг Зураг 1-с үзнэ үү/.

Санал хураалтыг мэдээллийн технологийн системийн оролцоотойгоор явуулж буй орнууд дараах шалтгаан, давуу талуудыг дурдсан байна. Үүнд:

- Санал хураалтын луйврыг бууруулах /Нэг гишүүн олон санал өгөх/;
- Санал хураалтын дүнг хурдан, шуурхай гаргах;
- Санал хураалтын дүнг нэг дор, автоматаар хүлээж авах;
- Парламентын үйл ажиллагаан дахь ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Зураг 1. Парламентын хуралдааны санал хураалтад ашиглаж буй цахим тоолуурын системийн төрлүүд
/112 танхим/



Эх сурвалж: World e-Parliament Report 2016, IPU
<http://www.ipu.org/pdf/publications/eparl16-en.pdf>

Нэг. Хурууны хээгээр санал өгөхийг хууль, журамд тусгасан байдал

Өдгөө парламентын санал хураалтад хурууны хээгээр санал өгөх системийг Албани, Болгар, Итали, Шри Ланк зэрэг орнууд нэвтрүүлж эхлээд байна. Хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлсэн улс орнуудын Дэг болон холбогдох бусад хууль, журмыг шүүн үзэхэд Болгараас бусад улсад холбогдох зохицуулалт тусгагдаагүй байна.

Албани. Албанийн Парламентын дэгийн 8-р бүлэгт Парламентын гишүүдийн ирц, санал хураалтын талаар тусгасан байна. 56-60-р заалтад санал хураалтад цахим тоолуурыг ашиглах талаар заасан боловч хурууны хээгээр санал өгөх зохицуулалт тусгагдаагүй байна.³

Болгар. Болгарын Парламент нь өөр гишүүний картаар санал өгөх асуудлыг халах зорилгоор 2010 онд хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлсэн боловч биометрик мэдээлэл цуглуулах, гишүүний карттай уялдуулах зэрэг асуудлаас болж хойшлогдон 2013 оны 6-р сараас эхлэн бүрэн хэрэгжиж эхэлсэн байна. Болгарын Парламентын дэгийн:⁴

“63.1-д: Саналыг зөвхөн өөрийн биеэр хүрэлцэн ирж өгнө. Үндэсний Ассамблейн гишүүд “тийм”, “үгүй” эсхүл “санал өгөхөөс татгалзах” гэсэн санал өгч болно. Хуульд өөрөөр заагаагүй бол Парламентаар хэлэлцэж, батлах бүхий л

³ http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf

⁴ <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

хууль, тогтоомжийн санал хураалтыг илээр явуулна. Үндэсний Ассамблейн бүрэн эрхийн хүрээнд тодорхой хууль, тогтоомжийн санал хураалтыг нууцаар явуулж болно.

63.2-т: Ил санал хураалтыг дараах хэлбэрээр явуулж болно:

1. Цахим санал хураалтын систем - the computerized voting system;
2. Гар өргөх;
3. Нэр дуудах - roll-call /Гишүүдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар дуудах бөгөөд гишүүд суудлаасаа “тийм”, “үгүй” эсхүл “санал өгөхөөс татгалзав” гэж санал өгөх эрхтэй байна/;
4. Санал хураах хуудсаар /хуулийн төсөлд гарын үсэг зурах/;
5. Цахим тоолуур ашиглан нэр дуудах-electronic roll-call /дэлгэцэн дээр гишүүдийн нэрс болон өгсөн саналыг гаргана/.

63.3-т: Санал хураалтыг цахим тоолуур ашиглан нэр дуудаж явуулах /63.2.5/ тохиолдолд саналыг төлөөлөгч (депутат) тус бүрийн биометрик үзүүлэлтийг ашиглан, эсхүл төлөөлөгч (депутат) тус бүрийн биометрик үзүүлэлтийг ашиглан идэвхждэг системийг ашиглан хураана.” гэж заажээ

Итали. Италийн Төлөөлөгчдийн танхим нь нэг гишүүн олон хүний өмнөөс санал өгч буйг таслан зогсоох зорилгоор хурууны хээгээр санал өгөх системийг 2010 онд нэвтрүүлсэн байна. Италийн Төлөөлөгчийн танхимын дэгийн 10-р бүлэгт Санал хураалтын асуудлыг тусгасан бөгөөд 49-р зүйлийн 4,5-д⁵ заасны дагуу ил болон нууц санал хураалтыг цахим тоолуурын системийг ашиглан явуулж болно гэж заасан байна.

Шри Ланк. Шри Ланк Улсын хувьд 2016 оны 11-р сараас Парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Парламентын дэгийн хувьд одоогоор хурууны хээгээр санал өгөх зохицуулалт тусгагдаагүй байна.⁶

Уганда. Уганда Улсын хувьд Парламентын хуралдааны санал хураалтад цахим тоолуурыг 2015 оноос ашиглаж эхэлсэн байна. Хурууны хээгээр санал өгөх зохицуулалт тусгагдаагүй бөгөөд зөвхөн гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэхээр төлөвлөсөн.

⁵http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf

⁶<https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

МХШҮХ-ийн Судалгаа, Мэдээлэл Лавлагааны албаны судалгаа:

1. “Парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгөх талаарх бусад орнуудын хуулийн зохицуулалт, техник, зохион байгуулалт” (СТ-17/403)

Ном бүтээл:

2. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг., 2015.
3. Л.Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй., 2010 он

Хууль тогтоомжийн холбоосууд:

4. www.assemblee-nationale.fr
5. http://www.parliament.nz/NR/rdonlyres/65E97824-9EED-447E-832A-E4A4418EAEA2/252153/standingorders2011_5.pdf
6. <http://www.diputados.gov.ar/frames.jsp?mActivo=institucional&p=http://www1.hcdn.gov.ar/dependencias/dip/congreso/regladip.pdf>
7. www.parlam.kz/ru/Home/status
8. www.lex.uz/
9. www.kenesh.kg/RU/Articles/1099-Reglament.aspx
10. www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=rus
11. http://www.congreso.es/portal/page/portal/Congreso/Congreso/Hist_Normas/Norm/standing_orders_02.pdf
12. <http://www.ipu.org/pdf/publications/epar16-en.pdf>
13. http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf
14. <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
15. http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf
16. <https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>
17. <http://www.independent.co.uk/news/uk/politics/electronic-voting-in-for-mps-in-parliament-could-improve-accuracy-of-how-votes-are-recorded-a6875766.html>
18. http://www.legco.gov.hk/general/english/library/stay_informed_parliamentary_news/electronic_recording_of_divisions.pdf
19. <http://www.lopparl.gc.ca/content/lopp/researchpublications/prb0028-e.htm#CBiometrics>
20. <http://www.haaretz.com/news/mks-reject-fingerprint-proposal-for-knesset-voting-1.92126>
21. http://www.parliament.go.ug/images/stories/constitution/rules_2012.pdf
22. <http://www.kontrax.bg/en/>,
23. http://computerworld.bg/inenglish/articles/34695_it_green_technologies_healthrelated_high_tech_products_and_services_are_key_areas_for_bulgaria
24. <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>
25. www.constituteproject.org